



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/66/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Д.Зэндмэнэ
Утас: 261628 Цахим хаяг: zendmened@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккурэйт финанс Аудит ХХК
Захирал: Ж.Оюунбилэг
Цахим хаяг: acc.fin.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Албан шаардлага	19
5. 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХАА	Хөдөө аж ахуй
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/341
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2022\0225 Auditlin 2 Газар -2.Docx

001050304

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	149,904,686.72	24,386,155.00
34	УРЬДЧИЛГАА	138,724,763.72	18,092,625.00
34600	Урьдчилж гарсан зардал	138,724,763.72	18,092,625.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,179,923.00	6,293,530.00
351	Түүхий эд материал	433,470.00	2,307,400.00
35110	Тусгай зориулалтын материал	433,470.00	2,307,400.00
354	Хангамжийн материал	10,746,453.00	3,986,130.00
35410	Бичиг хэргийн материал	1,431,560.00	249,320.00
35420	Аж ахуйн материал	9,314,893.00	3,736,810.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	748,498,527.97	662,970,310.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	748,498,527.97	662,970,310.45
392	Биет хөрөнгө	424,908,567.79	339,457,350.45
39201	Барилга байгууламж	86,767,692.00	86,767,692.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,745,512.85)	(20,286,299.25)
39203	Авто тээврийн хэрэгсэл	36,303,925.00	20,522,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,303,925.00)	(20,522,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж	785,381,258.00	765,845,258.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(463,530,711.26)	(519,775,965.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,371,309.99	48,188,159.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,686,685.33)	(23,632,712.07)
39209	Номын фонд	2,351,217.24	2,351,217.24
393	Биет бус хөрөнгө	323,589,960.18	323,512,960.00
39301	Программ хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(692,999.82)	(770,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	323,512,960.00	323,512,960.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	898,403,214.69	687,356,465.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	898,403,214.69	687,356,465.45
51	Засгийн газрын хувь оролцоо	898,403,214.69	687,356,465.45
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	563,664,858.93	563,664,858.93
51101	Өмч:-Төрийн өмч	563,664,858.93	563,664,858.93
512	Хуримтлагдсан үр дүн	255,334,340.70	57,805,747.77
51210	Өмнөх үеийн үр дүн	511,690,889.92	268,852,497.01
51220	Тайлант үеийн үр дүн	(256,356,549.22)	(211,046,749.24)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	79,404,015.06	65,885,858.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	898,403,214.69	687,356,465.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	999,842,470.00	1,320,371,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,891,570.00	85,470,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,891,570.00	85,470,000.00
12004	Төсөв байгууллагын орлого	13,891,570.00	85,470,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,891,570.00	85,470,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	985,950,900.00	1,234,901,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	792,590,900.00	787,206,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	792,590,900.00	787,206,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	193,360,000.00	447,695,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	72,800,000.00	191,489,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	120,560,000.00	256,206,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,256,199,019.22	1,531,418,449.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,256,199,019.22	1,531,418,449.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,227,103,842.99	1,522,851,966.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	667,526,830.00	678,741,689.60
210101	Цалин	489,660,389.20	536,029,230.12
210102	Нэмэгдэл цалин	148,480,860.80	102,990,959.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,385,580.00	39,721,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,577,595.86	89,389,409.14
210201	Тэтгэврийн даатгал	61,992,012.47	64,782,760.51
210202	Тэтгэмжийн даатгал	5,732,629.84	6,035,313.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,017,741.20	5,470,751.06
210204	Ажилгүйдлийн даатгал	1,118,224.48	1,107,519.05
210205	Эрүүл мэндийн даатгал	7,716,987.87	11,993,064.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	734,688.00	612,841.00
210301	Гэрэл цахилгааны зардал	734,688.00	612,841.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,745,332.91	43,468,312.50
210401	Бичиг хэрэг	9,220,250.00	3,050,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,069,500.00	756,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,513,582.91	969,112.50
210404	Ном, хэвлэлийн зардал	816,100.00	-
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	125,900.00	38,692,500.00
2105	Нормативт зардал	409,195.00	122,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	409,195.00	122,970.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,900,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,900,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	27,697,200.00	-
210702	Дотоод томилолтын зардал	27,697,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	379,999,849.00	617,508,527.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	376,580,549.00	614,294,722.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	71,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,000.00	116,061.00

210805	Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	22,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	246,400.00	246,400.00
210807	Газрын төлбөр	920,600.00	851,344.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,513,152.22	93,008,217.52
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,513,152.22	93,008,217.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,095,176.23	8,566,482.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	922,500.00	738,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	922,500.00	738,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,172,676.23	7,828,482.36
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	23,874,295.23	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,298,381.00	5,431,542.76
213305	Хөрөнгийн	-	2,396,939.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(256,356,549.22)	(211,046,749.24)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(256,356,549.22)	(211,046,749.24)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	990,960,900.00	1,234,901,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	990,960,900.00	1,234,901,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	792,590,900.00	787,206,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	792,590,900.00	787,206,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	198,370,000.00	447,695,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	77,810,000.00	191,489,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	120,560,000.00	256,206,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	986,006,500.00	1,232,401,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	986,006,500.00	1,232,401,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	956,911,323.77	1,223,835,217.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	664,146,757.00	678,741,689.60
210101	Үндсэн цалин	485,499,380.00	506,725,207.00
210102	Нэмэгдэл	164,922,977.00	167,141,483.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,724,400.00	4,874,999.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,577,595.86	89,389,409.14
210201	Тэтгэврийн даатгал	61,992,012.47	63,625,050.28
210202	Тэтгэмжийн даатгал	5,732,629.84	7,193,024.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,017,741.20	5,470,751.06
210204	Ажилгүйдлийн даатгал	1,118,224.48	1,107,519.05
210205	Эрүүл мэндийн даатгал	7,716,987.87	11,993,064.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	734,688.00	612,841.00
210301	Гэрэл цахилгааны зардал	734,688.00	612,841.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,979,182.91	4,914,212.50
210401	Бичиг хэрэг	9,634,100.00	3,189,000.00
210402	Тээвэр, шатахуун	889,500.00	756,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,513,582.91	969,112.50
210404	Ном, хэвлэлийн зардал	816,100.00	-
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	125,900.00	-
2105	Нормативт зардал	424,200.00	169,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	424,200.00	169,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,900,000.00	-

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,900,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	27,697,200.00	-
210702	Дотоод томилолтын зардал	27,697,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	161,451,700.00	450,007,165.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	158,032,400.00	446,793,360.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	71,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,000.00	116,061.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	246,400.00	246,400.00
210807	Газрын төлбөр	920,600.00	851,344.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,095,176.23	8,566,482.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	922,500.00	738,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	922,500.00	738,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,172,676.23	7,828,482.36
213301	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,874,295.23	5,431,542.76
213303	Хөрөнгийн	4,298,381.00	2,396,939.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,954,400.00	2,500,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,954,400.00	2,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,954,400.00	2,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,954,400.00	2,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,954,400.00	2,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,954,400.00)	(2,500,000.00)
8	САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
ЭХ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
ЭЦ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	563,664,858.93	79,404,015.06	511,690,889.92	1,154,759,763.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(127,509,196.11)	(127,509,196.11)
Дахин илэрхийлэх үлдэгдэл	563,664,858.93	79,404,015.06	384,181,693.81	1,027,250,567.80
Тайлант үеийн үр дүн	-	-	(256,356,549.22)	(256,356,549.22)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	563,664,858.93	79,404,015.06	255,334,340.70	898,403,214.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	13,518,156.31	13,518,156.31
Дахин илэрхийлэх үлдэгдэл	563,664,858.93	79,404,015.06	268,852,497.01	911,921,371.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(13,518,156.31)	-	(13,518,156.31)
Тайлант үеийн үр дүн	-	-	(211,046,749.24)	(211,046,749.24)
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	563,664,858.93	65,885,858.75	57,805,747.77	687,356,465.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	787,206,200.00	781,036,657.24	6,169,542.76	99.22
II	УРСГАЛ ЗАРДАЛЫН ДҮН	787,206,200.00	781,036,657.24	6,169,542.76	99.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	786,468,200.00	781,036,657.24	5,431,542.76	99.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	679,923,500.00	677,860,632.60	2,062,867.40	99.70
210101	Үндсэн цалин	491,912,400.00	505,844,150.00	(13,931,750.00)	102.83
210102	Нэмэгдэл	171,545,900.00	167,141,483.00	4,404,417.00	94.43
210103	Унаа болон бусад нөхөн олговор	16,465,200.00	4,874,99.60	11,590,200.40	29.61
21002	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,789,600.00	89,270,466.14	2,519,133.86	97.26
210201	Тэтгэврийн даатгал	64,592,700.00	63,506,107.28	1,086,592.86	98.32
210202	Тэтгэмжийн даатгал	6,799,200.00	7,193,024.15	(393,824.15)	105.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,439,400.00	5,470,751.06	(31,351.06)	100.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,359,800.00	1,107,519.05	252,280.95	81.45
210205	Эрүүл мэндийн даатгал	13,598,500.00	11,993,064.60	1,605,435.40	88.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	638,800.00	612,841.00	25,959.00	95.94
210301	Гэрэл цахилгаан	638,800.00	612,841.00	25,959.00	95.94
2104	Хангамж, бараа материалын зардал	2,381,600.00	1,914,212.50	467,387.50	80.38
210401	Бичиг хэрэг	189,000.00	189,000.00	-	100.00
210402	Тээвэр (шатахуун)	756,100.00	756,100.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	982,900.00	969,112.80	13,787.50	98.60
210404	Ном, хэвлэл	346,600.00	-	346,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэчдийн устгал, ариутгал	107,000.00	-	107,000.00	-
2105	Нормативт зардал	367,700.00	169,900.00	197,800.00	46.21
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	367,700.00	169,900.00	197,800.00	46.21
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,367,000.00	11,208,605.00	158,395.00	98.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,994,800.00	7,994,800.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	57,000.00	-	57,000.00	-

210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,600.00	116,061.00	14,539.00	88.87
210805	Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	17,600.00	-	17,600.00	-
210806	Мэдээллийн технологийн зардал	246,400.00	246,400.00	-	100.0
210807	Газрын төлбөр	920,600.00	851,344.00	69,256.00	92.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	738,000.00	738,000.00	-	100,0
2132	Бусад урсгал шилжүүлэг	738,000.00	738,000.00	-	100,0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	738,000.00	738,000.00	-	100,0
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	786,468,200.00	781,036,657.24	5,431,542.76	99.31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	786,468,200.00	781,036,657.24	5,431,542.76	99.31
131001	Улсын төсвөөс санхүүжих	786,468,200.00	781,036,657.24	5,431,542.76	99.31
15	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	738,000	-	738,000	
151001	Улсын төсвөөс санхүүжих	738,000	-	738,000	
65	АЖИЛЛАГСДЫН ТОО	45	45		100.0
650001	Удирдах ажилтан	1	1		100.0
650002	Гүйцэтгэх ажилтан	39	39		100.0
650009	Үйлчлэх ажилтан	5	5		100.0

.2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/
/Төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	445,298,560.40
II	УРСГАЛ ЗАРДАЛ	-	445,298,560.40
210	Бараа ажил үйлчилгээний зардал	-	445,298,560.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	881,057.00
210101	Үндсэн цалин	-	881,057.00
21002	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	118,943.00
210201	Тэтгэврийн даатгал	-	118,943.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,000,000.00
210401	Бичиг хэрэг	-	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	441,298,560.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	441,298,560.40
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	447,695,500.00
1301	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	447,695,500.00
130104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан, төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	191,489,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	256,206,000.00
39209	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,396,939.60

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Аккурэйт Финанс Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Бат-Эрдэнэ, аудитор Я.Золзаяа, аудиторын туслах А.Алтанчимэг нар гүйцэтгэж чанарын хяналтыг захирал Ж.Оюунбилэг, чанарын хяналтын менежер Л.Гоёцэцэг нар хэрэгжүүлсэн.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь ургамлын өвчин, хортон шавьж, мэрэгч амьтан, хог ургамлыг судлан тэмцэх арга боловсруулах, зохистой ашиглах, нөхөн сэргээх хүнсний эрүүл цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн ШУТ-ийн төсөл онолын суурь судалгаа, инноваци, цөм технологийн төслүүдийг захиалгаар гүйцэтгэдэг байгууллага.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол орны бэлчээр, хадлан, ой, ногоон байгууламж, таримал ургамлын өвчин, хортон шавьж, мэрэгч амьтан, хог ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, тархалт, хор хөнөөлийг тогтоож, хөнөөлт зүйлүүдийн био-экологийн онцлогийг судалж, өсөлт хөгжлийн зүй тогтол, тархалт, олшролтын прогноз гарган, тэмцэх цогцолбор арга, дэвшилтэт технологи боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх ургамлын гаралтай бүтээгдэхүүнд чанарын үнэлгээ, пестицидийн үлдэгдлийг судлах, байгаль орчинд халгүй аргыг боловсруулж, ургац нэмэгдүүлэх, эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр хангахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь БШУСайдын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 тоот тушаалаар баталсан Боловсрол шинжлэх ухааны сайдын

эрхлэх хүрээний байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилсэн нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Ковид-19 цар тахлын улмаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын ажилтнаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн, байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,256,199.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,562.0 мянган төгрөгөөр тогтоосон

Аудитыг гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,531,418.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 15,314.2 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 898,403.2 мянган төгрөгөөр буюу 23.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилгээ	138,724.8	18,092.6	(120,632.2)
Бараа материал	11,179.9	6,293.5	(4,886.4)
Үндсэн хөрөнгө	748,498.5	662,970.3	(85,528.2)
Нийт хөрөнгө	898,403.2	687,356.5	(211,046.7)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	898,403.2	687,356.5	(211,046.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	898,403.2	687,356.5	(211,046.7)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 6,293.5 мянган төгрөг болж 4,886.4 мянган төгрөгөөр буурсан нь 243,427.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 333,784.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, хандиваар аж ахуйн материал 85,470.0 мянган төгрөгийн орлого авсанаас шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 662,970.3 мянган төгрөг болж 85,528.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 7,480.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 93,008.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцоолон бүртгэсэн;

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 789,883.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,676.8 мянган төгрөгөөр бууруулж 787,206.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс байр ашиглалттай холбоотой зардлыг 98.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 412.5 мянган төгрөг, нормативт зардлыг 56.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил үйлчилгээний зардлыг 1,925.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллыг 184.5 мянган төгрөгөөр бууруулж 787,206.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 787,206.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 781,036.6 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, 781,036.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 781,036.6 мянган төгрөг буюу 98.22 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 98.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 412.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,925.0 мянган төгрөг, нормативт зардлыг зардлыг 56.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71805	Шинжлэх ухаан, технологи хөтөлбөр	787,206.2	781,036.6	6,169.5	99.22
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	786,468.2	781,036.6	5,431.5	99.31
1.2	80215	Суурь судалгааны төсөл	26,249.5	36,249.5	-	100.00
1.3	80215	Захиалгат төсөл	150,920.0	150,920.0	-	100.00
1.4	80215	Хамтарсан төсөл	2,030.0	2,030.0	80.0	100.00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаа нь Монгол орны бэлчээр, хадлан, ой, ногоон байгууламж, таримал ургамлын өвчин, хортон шавьж, мэрэгч амьтан, хог ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, тархалт, хор хөнөөлийг тогтоож, хөнөөлт зүйлүүдийн био-экологийн онцлогийг судалж, өсөлт хөгжлийн зүй тогтол, тархалт, олшролтын прогноз гарган, тэмцэх цогцолбор арга, дэвшилтэт технологи боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх ургамлын гаралтай бүтээгдэхүүнд чанарын үнэлгээ, пестицидийн үлдэгдлийг судлах, байгаль орчинд халгүй аргыг боловсруулж, ургац нэмэгдүүлэх, эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр хангах чиг үүрэгтэй.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан Суурь судалгаа, Захиалгат, Гадаад улстай хамтарсан 3 төсөл арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээнд дараах онцлох асуудлуудыг байна. Үүнд:

- Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээнд үндсэн үйл ажиллагааны зардалд 787,206.2 мянган төгрөг;
- БШУЯ, ШУТС, Шинжлэх ухааны, Суурь судалгааны захиалгат төслийн 191,489.5 мянга төгрөг;
- Нэмэлт төсөв: гэрээт ажил, шинжилгээ, судалгааны ажлын зардал 256,206.0 мянган төгрөг;
- ХАА хөдөөгийн хөгжлийн төсөлийн “Шар цаас, дамартай цаас” 85,470.0 мянган төгрөг байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн дугаар 299 “Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоолоор Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн “Орон тооны дээд хязгаар”-ыг 80 болгон өөрчилсөн байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, 3 мэдээллий хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2 “мэдээлэл

ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, Албан шаардлага хүргүүлэх,

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмжийн дагуу гаргасан судалгааг шалгагдагч байгууллагаар гаргуулан хянаж аудитдаа ашигласан болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ..

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 6,780.0 мянган төгрөгийн алдаа 4 зөрчил илэрүүлснээс 6,780.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулах зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад 4,960.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулаагүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,471.5 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн биелэлт 92.3 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	10,471.5	2	10,471.5	-	-	100.0
Албан шаардлага	1	-	-	-	-	-	84.6
Нийт дүн	3	33,593.1	2	33,593.1	1	-	92.3

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, санхүүжилтыг 2022 оны Боловсрол шинжлэх ухааны сайдын төсвийн багцад тусгахаар төлөвлөсөн 170,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий “төмс, хүнсний ногооны иж бүрдэл техник”-үүдийг зээлээр хүлээлгэн өгсөн, ашиглагч байгууллага нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,750.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрүүлснээс, 1,790.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 4,960.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага өглөө.

Залруулагдаагүй 6.750.0 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас 7,691.9 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийн Ахмад настан тэтгэвэрт гарсан ажилтан албан хаагчдад олговор 400.0 мянган төгрөгийг тооцоолон олгосон байна.
2. Харилцагч байгууллагуудад үзүүлсэн шинжилгээний төлбөрийн орлогыг цахим И баримаар баталгаажуулаагүй бүртгэлд тусгасан байна.

4.2 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Коронавирус халдвар /КОВИД-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээд гамшгаас хамгаалах бүх нийтийн зэрэгт шилжүүлж хөл хорио тогтоосон хугацаанд ажилчдад унаа, хоолны хөнгөлөлт 4,960.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь ЗГ-ын тогтоол 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 91, 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 104-р тогтоол "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай", Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан төсвийн хөрөнгийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан "төсвийн хөрөнгийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, Албан шаардлага хүргүүлэх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

мянган төгрөг

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
					Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:												
1	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2022/66/НА-СТА-ТШЗ	Нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийн Ахмад настан тэтгэвэрт гарсан ажилтан албан хаагчдад олговор 400.0 мянган төгрөгийг олгосон	Завсарын аудитаар зал	1	400.0	1	400.0			1	-					
2	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2022/66/НА-СТА-ТШЗ	Харилцагч байгууллагуудад үзүүлсэн шинжилгээний төлбөрийн 1,390.0 мянган төгрөгийн орлогыг цахим И баримаар баталгаажуулаагүй бүртгэлд тусгасан	Завсарын аудитаар зал	1	1,390.0	1	1,390.0				-					
3	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2022/66/НА-СТА-ТШЗ	Коронавирус халдвар /КОВИД-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, нийтийн зэрэгт шилжүүлж хөл хорио тогтоосон хугацаанд ажилчдад унаа, хоолны хөнгөлөлт 4960,0 мянган төгрөг олгосон	Завсрын аудитаар залруулах зөвлөмж өгсөн залруулаагүй тул Албан шаардлага хүргүүлэх	1	4,960.0					1	4,960.0					
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ:																	
4	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	АХГ-2022/66/НА-СТА-ТШЗ	Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, 3 мэдээллий	Албан шаардлага хүргүүлэх	1	-					1	-					

		хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй														
Дүн																
Нийт дүн			4	6,750.0	2	1,790.0	-	-	2	4,960.0	-	-	-	-		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 143/А0150058
АХТ-2022/66/НБ-СТА-ТХН

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 136 мэдээлэл оруулахаас 18 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал М.Бямбасүрэн, ерөнхий нягтлан бодогч А.Нэргүйбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ОЮУНБИЛЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherog\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-157.Docx

0010800502



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 143/А0150058
АХГ-2022/66/НА-СТА-ТХН

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 136 мэдээлэл оруулахаас 18 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал М.Бямбасүрэн, ерөнхий нягтлан бодогч А.Нэргүйбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ж.ОЮУНБИЛЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-157.Docx

0010800503

